



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 08 сарын 31 өдөр

Дугаар A/1435

Улаанбаатар хот

□ Хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг □
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын "Эрх шилжүүлэх тухай" 2020 оны А/228 дугаар захирамж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын "Үнэлгээний хороо байгуулах тухай" 2020 оны А/27 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ану гэгээн" ХХК-тай байгуулсан "Хорооны тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 1, 2, 20, 22, 33, 34, 35 дугаар хороо/" НХААГ-20/0073 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй хөрөнгийг хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. "Хорооны тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 1, 2, 20, 22, 33, 34, 35 дугаар хороо/" нийлүүлэх ажлын тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /С.Сэржаргал/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.РЭНЦЭНБЯМБА

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 31 өдрийн 1455 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

С.Сэржжаргал Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Эрдэнэмөнх Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Ганболд Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн /Зөвшилцсөнөөр/

Б.Болд Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хорооны Засаг дарга /Зөвшилцсөнөөр/

Б.Гантуяа Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хорооны Засаг дарга /Зөвшилцсөнөөр/

Х.Нэмэхбаяр Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны Засаг дарга /Зөвшилцсөнөөр/

Ж.Гантогтох Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны Засаг дарга /Зөвшилцсөнөөр/

М.Тэмүгэ Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хорооны Засаг дарга /Зөвшилцсөнөөр/

А.Батбаяр Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хорооны Засаг дарга /Зөвшилцсөнөөр/

Д.Баярсайхан Сонгинохайрхан дүүргийн 35 дугаар хорооны Засаг дарга /Зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

А.Эрдэнэмөнх Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн